



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
“БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 407

Бор-Өндөр

Г Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/545 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн хэмжээнд төрийн албан хаагчийн болон багшийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргах эрх бүхий ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: А.Алтанцэцэг (Бага ангийн багш)

Гишүүд: Н.Уранбайгаль (Бага ангийн багш)

Ж.Оюунгэрэл (Бага ангийн багш)

Д.Отгонгэрэл (Хөгжмийн багш)

Н.Мягмарцэцэг (Үйлчлэгч)

2. Зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан батлуулж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ч.АМАРЖАРГАЛ

